

8.4.26 Төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар  
хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт

2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр "Оргил таур" ХХК-тай гэрээ байгуулж, 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл сунгах гэрээ байгуулж, Улсын комисс 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр хүлээн авч ашиглалтанд оруулсан.



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1-Р СУРГУУЛИЙН ЗАСВАРЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр

Сэлэнгэ аймаг

**НЭГ. Ерөнхий зүйл**

1.1. Нэг талаас Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас “ОРГИЛ ТАУР” ХХК /Улсын бүртгэлийн дугаар 9011013118/ (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нар /хамтад нь “Талууд” гэх/ нь дараах зүйлийг харилцан тохиролцож, **2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр** энэхүү гэрээг байгуулав.

1.2. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу **Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн засварын ажил гүйцэтгэхтэй** холбогдуулан Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, Талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхойлоход энэхүү гэрээний зорилго оршино.

1.3. Энэхүү гэрээний үнэ нь шууд гэрээ байгуулах аргаар ирүүлсэн Гүйцэтгэгчийн үнийн саналд үндэслэгдсэн бөгөөд энэ гэрээний 1.4 дэх хэсэгт заасан ажлыг бүрэн хийж гүйцэтгэх нийт үнийн дүнтэй гэрээ (lump sum contract) тул гэрээний үнийн дүн ямар ч тохиолдолд өөрчлөгдөхгүй болохыг Талууд бүрэн хүлээн зөвшөөрсөн болно.

1.4. Энэхүү гэрээний хүрээнд дараах засварын ажлыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

- Дотор цэвэр, бохир усны ажил
- Узелийн ажил
- Дотор заслын ажил
- Бойлурын ажил
- Цахилгааны ажил
- Газардуулгын ажил

1.5. Энэхүү гэрээний 1.4 дэх хэсэгт заасан ажлын зураг нь гэрээний салшгүй хэсэг болно.

1.6. Барилгын засварын төслийн батлагдсан ажлын зураг, төсвийг Гүйцэтгэгч хянан үзэж бүрэн хүлээн зөвшөөрсөн болно.

**ХОЁР. Захиалагчийн эрх, хүлээх үүрэг**

2.1. Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан “Захиалагчийн чиг үүрэг”-ийг хэрэгжүүлнэ.

2.2. Захиалагч талыг төлөөлж зохиогчийн болон техник хяналтыг гүйцэтгэх эрх бүхий мэргэжлийн байгууллагын ажилтныг гэрээ байгуулсанаас хойш 7 хоногийн дотор томилон ажиллуулна. Сургуулийн сурагчдын аюулгүй байдал, засварын ажилд дэмжлэг үзүүлэх,

өдөр тутмын хяналтыг тавих, сургуулийн эд хөрөнгийг хамгаалах зорилго бүхий ажлын хэсэг болон ажилтныг томилон ажиллуулна.

2.3. Захиалагч нь гэрээт ажлын гүйцэтгэл, засвар хийх хугацаа, чанар, бүтээмжид байнгын хяналт тавих, сануулах, шаардах, дэмжлэг үзүүлэх зохицуулалт хийнэ.

2.4. Гүйцэтгэгч талд хөдөлмөр хамгаалал, техникийн болон галын аюулгүй ажиллагааны талаар холбогдох хууль журмыг сахин ханган ажиллахыг анхааруулан хариуцсан мэргэжилтнийг ажиллуулахыг албан бичгээр шаардана.

2.5. Талууд хамтран долоо хоногийн тогтсон өдөр /шаардлагатай үед зарлах/ гүйцэтгэлийн талаар мэдээлэл авах, гүйцэтгэгчээс шалтгаалсан асуудлыг шуурхай шийдвэрлэнэ.

2.6. Хэрэв Гүйцэтгэгч ажлын зураг төсвийн дагуу хийгээгүй, стандарт болон технологи зөрчсөн, чанаргүй хийсэн зэрэг доголдол засварын ажлын явцад илэрвэл ажлыг зогсоож доголдлыг арилгуулахыг шаардах, дахин гүйцэтгүүлэх, учирсан хохирлоо нөхөн төлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.7. Хэрэв ажлын шаардлага хангахгүй материал ашиглан барилгын ажлыг гүйцэтгэсэн тохиолдолд барилгыг ашиглахаас татгалзах, Гүйцэтгэгч талд шуурхай албан бичгээр мэдэгдэх, буцаах, солиулах, хохирлыг төлүүлэх зэрэг шаталсан арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

2.8. Засгийн газрын 2017 оны 68 дугаар тогтоолын дагуу засварын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгохтой холбогдсон арга хэмжээг авна.

2.9. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлд шаардагдах дараах нөхцлүүдийг бүрдүүлнэ. Үүнд:

2.9.1. Гэрээт ажлыг гүйцэтгэх шаардлагатай ажлын талбайг бэлтгэж, хүлээлгэн өгөх, буцааж хүлээн авах

2.9.2. Гэрээт ажилтай холбогдох зураг, баримт бичиг бүрдүүлэх

2.9.3. Цахилгаан, дулаан, ус болон шаардлагатай нөхцөлд гэрээнд нэмэлтээр тусгасан бусад зүйлсээр хангах;

2.10. Ажил гүйцэтгэх нөхцөл энэ гэрээний 2.9 дахь хэсэгт заасан нөхцөл бүрдсэн тухай Гүйцэтгэгчид албан бичгээр мэдэгдэнэ.

2.11. Гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагааны улмаас сургуулийн эд хөрөнгөд гэмтэл учруулсан тохиолдолд засах албан шаардлагыг Гүйцэтгэгчид бичгээр гаргаж мэдэгдэнэ.

2.12. Засварын ажлын явцын талаар санал, хүсэлт, гомдлыг Захиалагчийн томилсон хяналтын ажилтан албан бичгээр Гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

2.13. Сурагч, багш ажиллагсдын аюулгүй байдлыг бүрэн хангах, холбогдох хууль журмыг сахиулж ажиллана.

### **ГУРАВ. Гүйцэтгэгчийн эрх, хүлээх үүрэг**

3.1. Гүйцэтгэгч тал нь Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан “Барилгын ажил гүйцэтгэгчийн чиг үүрэг”-ийг хэрэгжүүлэх бөгөөд барилгын стандарт, дүрэм, норм нормативыг баримтлан ажиллана.

3.2. Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5-д заасны дагуу хөдөлмөр хамгааллын инженер томилж, засварын талбай, ажлын байранд хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагаа, галын аюулгүй ажиллагаа, ажиллагсад, сурагчдын аюулгүй байдлыг бүрэн хангаж холбогдох хууль журмыг сахиж ажиллана.

3.3. Гэрээний хугацаанд барилгын засварын ажлыг батлагдсан зургийн дагуу чанартай гүйцэтгэж, Захиалагчид актаар хүлээлгэж өгнө.

3.4. Гэрээт ажлыг батлагдсан төсөв, хуваарийн дагуу стандартын шаардлага хангасан барилгын материалаар гүйцэтгэнэ.

3.5. Гэрээт ажилтай холбоотой төрийн байгууллага, захиалагчийн томилсон хяналтын ажилтнуудаас гаргасан хууль ёсны шаардлага, санал хүсэлт, гомдол, мэдэгдэл, акт, дүгнэлтийг биелүүлнэ.

3.6. Гэрээт ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай мэргэжлийн орон тооны ажилчин, инженер техникийн ажилчдыг ажиллуулах бөгөөд гэнэтийн ослын даатгалыг хариуцан хийлгэсэн байна.



3.7. Гүйцэтгэгч тал нь Захиалагчийн томилсон хяналтын инженер, сургуулийн удирдлага, ажилтантай ажил хэргийн тэгш харилцаатай ажиллана.

3.8. Гүйцэтгэгч талын удирдлага нь ажилчдыг засварын талбай, сургуулийн орчинд архидан согтуурах, танхайрах, дураараа сэлгүүцэх, хог тарих, харуул жижүүрийн тавьсан шаардлагыг биелүүлэхгүй байх зэрэг ёс зүйн болоод эрх зүйн зөрчил гаргуулахгүй байх асуудлыг хариуцна.

3.9. Энэхүү гэрээгээр талууд материалын тоо хэмжээ, барилгын засварын хугацааг харилцан тохиролцсон тул тоо хэмжээний зөрүү, гэрээний хүчинтэй хугацаанд болон хугацаа хэтэрснээс үүсэх аливаа эрсдэл, материалын үнийн өсөлт зэргийг Гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

3.10. Гүйцэтгэгч тал нь барилгын ил далд ажлын акт, барилгын ажлын явцын фото зураг зэрэг холбогдох баримт бичгүүдийн эх хувийг Захиалагчид, хуулбар хувийг сургуулиас томилогдсон ажилтанд тухай бүр танилцуулан, хүлээлгэн өгнө.

3.11. Захиалагч талаас ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх, асуудлыг хамтран шуурхай шийдвэрлэхэд идэвхтэй оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгэж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

3.12. Гүйцэтгэгч тал нь өдөр тутам ажлын байр, тоног төхөөрөмжийн эмх цэгц, цэвэрч аюулгүй ажиллагааг хэвшүүлэн ажиллана.

3.13. Гүйцэтгэгч нь засварын ажлыг бусдад дамжуулах, бусдаар туслан гүйцэтгүүлэх, зуучлахыг хориглоно.

3.14. Гэрээнд өөрчлөлт нэмэлт оруулах саналаа бичгээр гаргана.

3.15. Монгол улсын барилгын тухай хуулийн 14.3-т заасны дагуу барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа **1 жил байхыг бичгээр** гаргаж өгнө.

3.16. Барилга байгууламжийг зүгшрүүлэх, тохируулах хугацаа дуусгавар болсноос хойш Гүйцэтгэгч нь гүйцэтгэсэн ажилдаа **3 жилийн баталгаат хугацаа бичгээр** гаргаж өгнө.

3.17. Ажил хүлээлцэх үед болон ашиглалтанд оруулах комиссын актын дагуу хүлээж авсны дараа засварын ажлын доголдол илэрсэн тохиолдолд доголдлыг Гүйцэтгэгч 3-5 хоногийн дотор засварлах буюу хохирлыг арилгана.

3.18. Гүйцэтгэсэн ажил, материалтай холбоотой гүйцэтгэлийн болон баталгаат хугацаанд Захиалагчаас үл хамаарсан эвдрэл гэмтлээс үүдсэн хохирлыг Гүйцэтгэгч тал өөрийн хөрөнгөөр засч бүрэн бүтэн болгоно. Хэрэв үүссэн эвдрэл, гэмтлийг засч хохирлыг барагдуулаагүй, түүний дүн нь гүйцэтгэлийн баталгааны дүнгээс хэтэрсэн тохиолдолд үүссэн хохирол, алдангийг Гүйцэтгэгч Захиалагч талд нэмэж төлнө.

3.19. Гүйцэтгэгч байгууллага нь ажиллах хүн хүчний нөөцөө зөв тодорхойлж гэрээний хугацаанд хүлээлгэж өгнө.

3.20. Гүйцэтгэгч **“ОРГИЛ ТАУР” ХХК** нь **Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн засварын ажлыг 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрөөс эхэлж, 2023 оны 10 дугаар сарын 01-ны өдөр буюу 35 хоногийн дотор** бүрэн ашиглалтанд оруулна.

3.21. Сурагч, багш, ажиллагсдын аюулгүй байдлыг бүрэн хангах холбогдох хууль журмыг сахиулан биелүүлнэ.

### **ДӨРӨВ. Гэрээний үнэ**

4.1. Гэрээний үнэ **669,314,637.0** (зургаан зуун жаран есөн сая гурван зуун арван дөрвөн мянга зургаан зуун гучин долоон) төгрөг болно. (НӨАТ орохгүй)

4.2. Гэрээний үнэд бүх татвар, хураамж, ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай бүх материалын үнэ багтсан болно.

4.3. Гүйцэтгэгч бүх материалуудыг Захиалагчид хүлээлгэн өгсний дараа Захиалагч гэрээний санхүүжилтийг Гүйцэтгэгчид шилжүүлнэ.

4.4. Гүйцэтгэгч шаардлагатай материалыг санхүүжилт хүссэн албан бичиг, нэхэмжлэлийн хамтаар Захиалагчид хүлээлгэн өгч, Захиалагч нь тухайн материал нь зөрчил дутагдалгүй болохыг нягталсны дараа ажлын 20 хоногт Гүйцэтгэгчийн дансанд шилжүүлнэ.

4.5. Гэрээний үнийг дараах байдлаар Гүйцэтгэгчийн нэхэмжлэлийг үндэслэн Захиалагч төлнө. Үүнд:

4.5.1. Нэгдүгээр санхүүжилтийн дүн: Гэрээний дүнгийн 40 хувь буюу **267,725,855.0 (хоёр зуун жаран долоон сая долоон зуун хорин таван мянга найман зуун тавин таван)** төгрөг нь зөвхөн доорхи нөхцлийг хангасан тохиолдолд төлөгдөх бөгөөд Гүйцэтгэгч нь дараах нөхцлийн аль нэгийг нь сонгож болно.

4.5.1.1. Нэгдүгээр санхүүжилт болох 40 хувьтай тэнцэх **267,725,855.0 (хоёр зуун жаран долоон сая долоон зуун хорин таван мянга найман зуун тавин таван)** төгрөгийн банкны урьдчилгаа төлбөрийн баталгаа, /гүйцэтгэлийн баталгааг оруулж тооцно/ болон Гүйцэтгэгчийн санхүүжилт хүссэн материалыг хүлээн авсны үндсэн дээр.

4.5.1.2. Ажлын гүйцэтгэл 40-өөс дээш хувьд хүрч дараах материалыг хүлээн авсны үндсэн дээр төлөгдөнө. Шаардлагатай материал: Гүйцэтгэгчийн санхүүжилт хүссэн нэхэмжлэх, гүйцэтгэлийн тайлан, газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дүгнэлт, засварын явцыг баталгаажуулсан фото зураг.

4.5.2. Хоёрдугаар санхүүжилтийн дүн: Гэрээний дүнгийн 30 хувь буюу **200,794,391 (хоёр зуун сая долоон зуун ерэн дөрвөн мянга гурван зуун ерэн нэгэн)** төгрөгийг ажлын гүйцэтгэлийн явц 70-аас дээш хувьд хүрч дараах шаардлагатай материалыг хүлээн авсны үндсэн дээр төлнө. Шаардлагатай материал: Гүйцэтгэгчийн санхүүжилт хүссэн нэхэмжлэх, гүйцэтгэлийн тайлан, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дүгнэлт, гүйцэтгэлийг баталгаажуулсан фото зураг.

4.5.3. Гуравдугаар санхүүжилтийн дүн: Гэрээний дүнгийн 30 хувь буюу **200,794,391 (хоёр зуун сая долоон зуун ерэн дөрвөн мянга гурван зуун ерэн нэгэн)** төгрөгийг ажлын гүйцэтгэлийн явц 100 хувьд (ажил дуусч) хүрч дараах шаардлагатай материалыг хүлээн авсны үндсэн дээр төлнө. Шаардлагатай материал: Гүйцэтгэгчийн санхүүжилт хүссэн нэхэмжлэх, гүйцэтгэлийн тайлан, комиссын акт, ил далд ажлын актууд, аудитын дүгнэлт болон гүйцэтгэлийн тайлан, явцыг баталгаажуулсан фото зураг.

#### **ТАВ. Давагдашгүй хүчин зүйл**

5.1. Гэрээний хугацаанд гал түймэр, үер ус, бусад байгалийн гамшиг, дайн дажин, зэрэг давагдашгүй хүчин зүйлс үүссэнээс гэрээг хэвийн үргэлжлүүлэх боломжгүй болсон ч гэрээ хүчин төгөлдөр байна. Хэрэв энэхүү байдал нь хоёроос дээш сараар үргэлжилж гэрээний аль нэг тал нь гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл гэрээ дуусгавар болох ба 14 хоногийн өмнө нөгөө талдаа мэдэгдэж харилцан тохиролцоно.

#### **ЗУРГАА. Маргаан шийдвэрлэх**

6.1. Гэрээний явцад маргаан гарвал Талууд зөвшилцөж шийдвэрлэнэ.

6.2. Зөвшилцөлд эс хүрвэл гэрээний аль нэг тал нийтлэг үндэслэлд заасан хуулийн болон гэрээний заалтуудыг үндэслэн шүүхэд гомдол гарган шийдвэрлүүлнэ.

#### **ДОЛОО. Бусад**

7.1. Гэрээт ажлын дэлгэрэнгүй агуулгыг тусгасан хавсралт, зураг төсөв нь тус гэрээний салшгүй нэг хэсэг болно.

7.2. Гэрээнд холбогдох асуудлаар Талууд албан бичгээр харилцана.

7.3. Талууд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

7.4. Гүйцэтгэгч нь Япон улсын Засгийн газрын Хөгжлийн Албан Ёсны Тусламжийг сурталчилан таниулах самбар хийж байршуулна. Самбарын хэмжээ, загвар, байршуулах



газрыг Захиалагч тал болон сургуультэй урьдчилан зөвшилцөж шийднэ. Тус зардалыг энэхүү гүйцэтгэлийн гэрээнд багтсан гэж тооцно.

7.5. Шаардлагатай тохиолдолд Талууд харилцан тохиролцож, гэрээнд нэмэлт өөрчлөлтийг зөвхөн бичгээр оруулна.

7.6. Гүйцэтгэгч гэрээний үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх гүйцэтгэлийн баталгааг гэрээ байгуулсанаас хойш ажлын 5 өдрийн дотор гаргаж Захиалагчид хүргүүлнэ. Гүйцэтгэлийн баталгаа нь ажлыг хүлээн авсан акт баталгаажсан хугацаанаас хойш 1 жил байна.

7.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад Талууд хамтран шийдвэрлэх асуудал гарвал харилцан зөвшилцөж шийднэ.

7.8. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, Захиалагчид 2 хувь, Гүйцэтгэгчид 1 хувь тус тус хадгална. Гэрээний хувь тус бүр хуулийн хүчинтэй байна.

### ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

#### ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

 /Я. Мөрөн/

(Тамга)

Утас: 99059632, 70362266

Хаяг: Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум, Цагаан эрэг 2-р баг Нутгийн удирдлагын ордон

#### ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ОРГИЛ ТАУР” ХХК-ийн захирал

 /Я.Сайнжаргал/


(Тамга)

Утас: 99095738, 95680509

Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 5 хороо 6-р хороолол 20-45 тоот

Харилцагч банкны нэр: Хас банк

Дансны дугаар: 5001169410

БАТЛАВ  Н.ЛХАГВАДОРЖ /СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА/

**“СЭЛЭНГЭ АЙМГИЙН СҮХБААТАР СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1-Р СУРГУУЛИЙН ЗАСВАР”-ЫН АЖЛЫН ХУГАЦАА СУНГАХ ГЭРЭЭ**

2023.10.01

Сүхбаатар сум

1.1. Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар түүнийг төлөөлж аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Я.Мөрөн (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас “Оргил таур” ХХК (улсын бүртгэлийн дугаар 9011013118) түүнийг төлөөлж захирал Я.Сайнжаргал (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож энэхүү хугацаа сунгах гэрээг (цаашид “гэрээ” гэх) байгуулав.


1.2. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын болон бусад хууль тогтоомжийн дагуу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Ерөнхий боловсролын 1-р сургуулийн засварын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулсан ба хичээлийн шинэ жил эхэлж, багш, сурагчдын ажиллах, сурах ая тухтай нөхцөл боломжийг хангаж, хичээлийн цагаар засварын ажил гүйцэтгэхгүй байх талаар ашиглагч байгууллагын ирүүлсэн хүсэлтийн дагуу ажлын бус цагаар засварын ажлыг гүйцэтгэж байгаатай холбогдуулан гэрээний хугацааг сунгав.

1.3. 2. Энэхүү гэрээ нь 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдөр байгуулсан ажил гүйцэтгэх гэрээний үргэлжлэх хэсэг болох бөгөөд үндсэн гэрээний заалтууд бүрэн хэрэгжинэ. Ажил гүйцэтгэх хугацааг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдөр хүртэл сунгав.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**


Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга

 Я.Мөрөн

Утас:99059632, 70362266  
Хаяг:Сэлэнгэ аймаг Сүхбаатар сум,  
Цагаан эрэг 2-р баг Нутгийн  
удирдлагын ордон

**ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

“ОРГИЛ ТАУР” ХХК-ийн захирал

 Я.Сайнжаргал

Утас:99095738, 95680509  
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй  
дүүрэг 5 хороо 6-р хороолол 20-45  
тоот  
Харилцагч банкны нэр:Хас банк  
Дансны дугаар: 5001169410

**Нээлттэй мэдээллийг дэлгэрүүлж авах, тодруулах эрх бүхий ажилтан:  
Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын  
хэлтсийн мэргэжилтэн С.Өлзийбүрэн 95629909**